



МАНДАЛ
даатгал

Мандал Даатгал ХК



МАНДАЛ
даатгал

2018 ОНЫ 4-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ 2018 ОНД ӨСӨЛТИЙН ХУРДАА ХАДГАЛЖ, АШИГТ АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙГ БАРИМТЛАН АЖИЛЛАСНЫ ҮР ДҮНД САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР САЛБАРТАА ТЭРГҮҮЛЭН ДААТГАЛЫН САЛБАРЫН №1 КОМПАНИ БОЛЛОО.

2018 онд гаргасан үр дүнгүүдээс дурдвал:

- 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөгөө 90 хувь давуулан биелүүллээ. Тайлант хугацаанд хураамжийн орлого 23 хувиар өссөн бол үйл ажиллагааны зардал харьцангуй бага буюу 15 хувиар өссөн байна.
- 2018 оны 9-р сард МХБ-ээр дамжуулан IPO хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшүүлэн 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татсанаар нээлттэй хувьцаат компани боллоо. Мандал Даатгалын хувьцаа МХБ-ийн I ангилалд багтсан бөгөөд 2019 оны ТОП 20 индексд багтлаа.
- Эрүүл мэндийн даатгалаар даатгуулагчдын тоо 6000, хураамжийн орлого 5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хувийн эрүүл мэндийн даатгалын 70 хувийг дангаараа бүрдүүлж байна.
- БНСУ-н Сөүл хотын Yonsei нэгдсэн эмнэлэг, CM гэмтлийн эмнэлэг, Дээгү хотын Kuompragda нэгдсэн эмнэлэг, W гэмтлийн эмнэлэгтэй хамтын ажиллаганы санамж бичиг байгуулснаар даатгуулагчид маань тухайн эмнэлгүүдээр үйлчлүүлэх боломж бүрдлээ.
- Байгууллагын хэмжээнд ажилтнуудын ашиглаж байгаа программ хангамжуудыг лицензжүүлж Microsoft office 365 шийдлийг нэвтрүүлснээр мэдээллийн аюулгүй байдлын түвшин нэг шат ахилаа.
- 2018 оны 10-р сард шинэ оффист нүүн орсноор харилцагчиддаа илүү ойртон, ая тухтай орчинд үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүллээ.

АЛСЫН ХАРАА

АЗИЙН ТАВЦАНД ӨРСӨЛДӨХ ДААТГАЛ САНХҮҮГИЙН ОЛОН УЛСЫН БРЭНДИЙГ БИЙ БОЛГОХ

Мандал Даатгал үүсгэн байгуулагдснаасаа хойш харьцангуй богино хугацаанд салбартаа тэргүүлэгч даатгалын компани болсон. Мандал Даатгалын алсан хараа нь зөвхөн Монголын шилдэг даатгалын компани болсноор хязгаарлагдахгүй, Азийн орнуудын зах зээлд гарч өрсөлдөх Монгол брэндийг бий болгох явдал юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО


ӨНӨӨДРӨӨ БАТАЛГААЖУУЛСАН МАРГААШИЙГ ИРГЭН БҮРТ

Даатгалын компанийн нийгэмд оруулж буй хамгийн том хувь нэмэр нь иргэдийг гэнэтийн эрсдэлээс үүдэн бий болох санхүүгийн хохиролд өртөхөөс хамгаалж, амьдралын хэмнэлийг нь баталгаажуулах явдал юм. Мандал Даатгал нь хувь хүн, өрх гэр, албан байгууллага тус бүр өнөөдрийг хүртэл бий болгосон өөрийн баялгийг тулгарч болох эрсдэлээс хамгаалан маргаашийнхаа зорилгын төлөө ажиллаж амьдардаг сайхан нийгмийг даатгалаараа дамжуулан бүтээхийг зорьдог.

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Мандал даатгал ХК нь 2018 оны 9 сарын 4-өөс 18-ны хооронд нийт хувьцааныхаа 25%-ийг МХБ-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосноор даатгалын салбараас анхлан IPO гаргасан. Нийт 7.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээс 9.2 тэрбум төгрөгийн захиалга ирж 23%-аар давж биелэлээ. 9-р сарын 24-ны өдрөөс эхлэн хоёрдогч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж байна.

2018 оны байдлаар 71,084 хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж, нийт 27.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллалаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23%-аар өссөн үзүүлэлт бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 113%-ийн биелэлттэй байна.



Хураамжийн орлогын 91 хувийг голлох 6 даатгалын хэлбэр эзэлж байгаа бөгөөд эдгээр 6 бүтээгдэхүүний багц харьцангуй жигд байна.

Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр



Иргэдийн даатгал/Байгууллагын даатгалын харьцаа


42/58

Цэвэр хураамж/Давхар даатгалын харьцаа


65/35

2018 онд нийт 7,293 даатгуулагчид 4.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Нийт нөхөн төлбөрийн зардал өнгөрсөн оноос 8%-аар буурчээ.


Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо



Нөхөн төлбөр, тэрбум төгрөг



Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр



- Тээврийн хэрэгслийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Хариуцлагын даатгал
- Бусад


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Мандал даатгал ХК нь 2018 онд хураамжийн орлогын төлөвлөгөөгөө 13%-аар давуулан биелүүлж, олон нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгон санхүүжилт татсанаар санхүүгийн үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт гарлаа.


Нийт хөрөнгийн хэмжээ 33.8 тэрбум төгрөгт хүрч өссөний 22.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ нь компанийн хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, ашигт ажиллагааг дээшлүүлэх суурь болж байна.

2018 онд 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар цэвэр ашгийн жилийн төлөвлөгөөг 1.9 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлээд байна.

Нийт хөрөнгө, тэрбум төгрөг




Мөнгөн хөрөнгө, тэрбум төгрөг



Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг



Цэвэр ашиг, тэрбум төгрөг



Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж



Санхүүгийн байдлын тайлан


сая төгрөгөөр	2016	2017	2018
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,720	1,805	3,082
Даатгалын авлага	3,350	4,402	4,817
Бусад санхүүгийн хөрөнгө	445	401	304
Бусад санхүүгийн бус хөрөнгө	190	182	1,233
Хөрөнгө оруулалт	3,258	9,229	19,837
Даатгалын хөрөнгө	5,711	4,869	3,889
ДД-ын хойшлогдсон хураамж	4,771	3,626	2,857
Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	335	715	548
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	606	528	484
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	294	289	352
Биет бус хөрөнгө /Цэвэр/	105	57	33
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	237	237	237
НИЙТ ХӨРӨНГӨ	17,309	21,472	33,784
Даатгалын өглөг	2,037	2,055	1,065
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	-
Бусад санхүүгийн бус өр төлбөр	677	1,139	646
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	7,473	9,366	13,115
Нөхөн төлбөрийн нөөц сан	2,224	2,911	3,383
Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	287	334	741
Мэдсэн боловч төлөөгүй ХНС	305	702	720
Учирч болзошгүй ХНС	375	618	666
Тусгай нөөц сан	1,256	1,256	1,256
Нийт өр төлбөр	12,411	15,471	18,210
Эзэмшигчдийн өмч	6,243	6,243	6,243
Халаасны хувьцаа	(1,243)	(1,243)	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-	4,442
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(102)	1,001	4,869
Нийт эздийн өмч	4,898	6,001	15,575
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	17,309	21,472	33,784

Орлогын тайлан

сая төгрөгөөр	2016	2017	2018
Нийт хураамжийн орлого	13,093	22,533	27,786
Даатгалын хураамжийн буцаалт	(973)	(1,208)	(1,530)
Давхар даатгалын хураамжийн зардал	(7,419)	(11,244)	(9,807)
Цэвэр хураамжийн орлого	4,701	10,081	16,449
ОТХНС-ийн өөрчлөлт	(5,255)	(1,893)	(3,749)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	4,771	(1,145)	(769)
Орлогод тооцсон хураамж	4,217	7,043	11,932
Нийт нөхөн төлбөрийн зардал	4,116	4,706	4,324
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	2,115	2,534	790
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	111	98	248
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	1,891	2,074	3,286
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	239	444	425
НТНС-ийн ДД-д ногдох хэсгийн өөрчлөлт	(335)	(380)	166
УБХНС-ийн өөрчлөлт	236	243	48
Зардалд тооцсон нөхөн төлбөр	2,030	2,381	3,925
Даатгалын гэрээний зардал	(1,121)	(1,204)	(1,316)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	1,271	925	439
Хөрөнгө оруулалтын олз, гарз	994	1,227	2,248
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	3,330	5,610	9,378
Хүү, эрхийн шимтгэлийн орлого	23	28	28
Бусад орлого	27	63	75
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,686)	(3,522)	(3,987)
Борлуулалт, маркетингийн зардал	(456)	(517)	(608)
Бусад зардал	(5)	(417)	(555)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(62)	28	81
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(8)	(39)
Татварын өмнөх ашиг (алдагдал)	171	1,265	4,374
Татварын зардал	(85)	(163)	(505)
ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	85	1,103	3,868

ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

9-р сарын 24-нд хоёрдогч зах зээлд хувьцаагаа арилжаалж эхэлснээс хойш 2018 онд 2.2 тэрбум төгрөгийн арилжаа явагдаад байна.



2018/12/31-ний байдлаар

Өдрийн дундаж
арилжааны дүн

22.6 сая

EPS харьцаа

620

P/E харьцаа

8.5

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Мандал Даатгал компанийн эрх барих дээд байгууллага нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал” юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

Мандал Даатгал компани IPO гарган нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 12-нд Блю Скай зочид буудлын Кристал танхимд зарлан хуралдуулсан билээ. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан. Үүнд:

1. Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах;
2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох;
3. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Мандал Даатгал компанийн ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

Мандал Даатгал компанийн дүрэм тусгагдсанаар ТУЗ нь 9 гишүүнтэй байхаас 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ.

2018 оны 12 сарын 12-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын үр дүнд үндэслэн “Мандал даатгал” компанийн ТУЗ-ийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсон байна.

Ердийн гишүүнээр:

- Өлзийбаяр ГАНЗОРИГ
- Нямдаваа МОНСОР
- Очирпүрэв ГАНЖОЛОО
- Амартүвшин АМУНДРА
- Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ
- Батсайхан ЖАВХЛАН

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- ЖЭЙМС Бернард Двайер
- Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
- Нямандэлэг МАНДУУЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



Өлзийбаяр ГАНЗОРИГ
ТУЗ-ийн дарга



Очирпүрэв ГАНЖОЛОО
ТУЗ-ийн гишүүн



Нямдаваа МОНСОР
ТУЗ-ийн гишүүн



Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн гишүүн



Батсайхан ЖАВХЛАН
ТУЗ-ийн гишүүн



Амартүвшин АМУНДРА
ТУЗ-ийн гишүүн



**Жамсрандорж
ДЭЛГЭРСАЙХАН**
ТУЗ-н хараат бус гишүүн



**ЖЭЙМС БЕРНАРД
ДВАЙЕР**
ТУЗ-н хараат бус гишүүн



Нямандэлэг МАНДУУЛ
ТУЗ-н хараат бус гишүүн